

## **Байгаль орчин нөхөн сэргээлттэй холбоотойгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээ**

*1. Хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээний явцад байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл, үр дагавар, тэдгээрийг арилгах арга хэмжээг тогтоосон байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний талаарх мэдээлэл, газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн мэдээлэл:*

Тус үйлдвэрийн газар нь өөрийн үйлдвэрлэл, үйл ажиллагааны явцад байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг тодорхойлж, тэдгээрийг бууруулах, арилгах арга хэмжээг авах зорилгоор доор дурдсан үйл ажиллагаа явуулж буй төслүүдийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, батлуулан ашиглаж байна. Тухайлбал:

- “Бор-Өндөр, Адагийн далд уурхай ба баяжуулах үйлдвэрийн төсөл – 2020 он,
- “Баргилтын төмрийн хүдрийн ордыг ашиглах төсөл” – 2018 он,
- “Зүүн цагаан дэл хайлуур жоншны ордыг далд аргаар ашиглах төсөл” – 2021 он,
- “Тэсрэх бодисын үйлдвэр, агуулахын төсөл” – 2018 он,
- “Хөх дэлийн хайлуур жоншны ордыг ашиглах төсөл” – 2018 он,
- “Бор-Өндөр” УБҮ-ийн Химилабораторийн төсөл” – 2022 он,
- “Туул голын гольдрилын алтны шороон ордыг ашиглах төсөл” – 2018 он,
- “Улаан-Уулын алтны шороон ордыг ашиглах төсөл” – 2021 он

Түүнчлэн, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Ашигт малтмалын тухай хуулийн дагуу шинээр ашиглаж эхэлсэн, хугацаа нь дууссан, эсхүл нэмэлт тодотгол хийх шаардлагатай болсон төслүүдийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг хийлгэхээр зөвлөх компанитай гэрээ байгуулан ажиллаж байна.

*2. Мэдээлэл хариуцагчийн явуулж байгаа үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж байгаа техник технологийн хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийн талаарх мэдээлэл:*

“Монголросцветмет” ТӨҮГ-ийн ашиглалт явуулж буй төслүүдийн талбайд ухаш, хөрсний овоолго үүсгэх, ачилт тээвэрлэлт хийх, уурхайн шүүрлийн усыг шавхан зайлуулах, баяжмал үйлдвэрлэлт зэргээс шалтгаалан байгаль орчинд хүчтэй нөлөөлөл үүсгэнэ. Түүнчлэн, байгаль орчинд дунд болон бага нөлөө үзүүлэх нөлөөллүүд байх ба эдгээрийг тухайн төслийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлан тус бүрт тодорхойлуулж, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний төлөвлөгөөг цаг тухайд нь авч ажиллаж байна.

*3. АМТХуулийн 42-р зүйлд заасны дагуу Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагаас тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээ:*

“Монголросцветмет” ТӨҮГ нь 6 аймгийн 11 сумын нутагт ашигт малтмалын ашиглалт, хайгуулын 30 тусгай зөвшөөрөл эзэмшдэг.

- o Хэнтий аймгийн Бор-Өндөр сум – Ашиглалт,
- o Хэнтий аймгийн Дархан сум – Ашиглалт,
- o Дорноговь аймгийн Айраг сум – Ашиглалт,
- o Дорноговь аймгийн Иххэт сум – Ашиглалт,
- o Дорноговь аймгийн Өргөн сум – Ашиглалт,
- o Дундговь аймгийн Баянжаргалан сум – Ашиглалт,
- o Төв аймгийн Заамар сум – Ашиглалт,
- o Булган аймгийн Бүрэгхангай сум – Ашиглалт,
- o Увс аймгийн Наранбулаг сум – Ашиглалтын хайгуул

Үүнээс үйл ажиллагаа явуулж доорхи төслүүдийн хүрээнд Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулан ажиллаж байна. Үүнд:

Дээрх сумдын засаг захиргаатай байгуулсан Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх гэрээний хүрээнд “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, уурхай, үйлдвэрлэл, дэд бүтцийг хөгжүүлэх, соёлын өвийг хамгаалах, орон нутгаас ажлын байранд хүн ажиллуулах, ногоон байгууламж байгуулах болон хог хаягдлын чиглэлээр хамтран ажиллахаар тодорхой ажлуудыг тусган ажиллаж байна.